



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/68

Сүхбаатар сум

### Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Захирамжийн хавсралтад дурдсан газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхээр хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийн дагуу 2 иргэнд 2 нэгж талбарын 1064м<sup>2</sup> газрын эзэмших эрхийг шилжүүлэн авагчдад анх олгосон хугацаагаар шилжүүлсүгэй.

2.Дээрх газарт кадастрын зураглал хийн, нэгж талбарын хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлт оруулж, гэрчилгээ олгон эрхийг нь баталгаажуулж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хотбайгуулалтын газрын дарга (Б.Саруул-төгс)-д даалгасугай.

3.Эзэмшил газраа зориулалтын дагуу ашиглаж арваас доошгүй хувьд ногоон байгууламж бүрдүүлэн, тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг хавсралтад дурдсан газар эзэмших эрх шилжүүлэн авагч 3 иргэнд үүрэг болгосугай.

4.Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ж.Отгонхүү)-д хариуцуулсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтад дурдсан нэр бүхий 2 шилжүүлэгчийн эзэмшилд олгосон аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/248, 2012 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/344 дугаартай захирамжийн холбогдох заалт, дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш. ОРГИЛ

My Doc Zahiramj

Сэлэнгэ аймгийн Засаг Даргын  
2019 оны 03 сарын 17-ны өдрийн  
А/д... тоот захирамжийн 1-р хавсралт

№	Эрх шилжүүлэн авагч		Эрх шилжүүлэгч		Эрх шилжүүлэн авагчид эзэмшүүлэх газрын талбай (м2)	Нэгж талбарын дугаар	Байршил	Эрх шилжүүлэн авагчийн талбай (м2)	Шилжүүлэн авагчийн эзэмшлэгчдийн нийт талбайн хэмжээ (м2)	Газрын зориулалт	Газрын зориулалт хугацаа	Гэр бүлийн хамтын хэрэгцээний оноос жил	Хүчингүй болж байгаа захирамжийн он сар өдөр, захирамжийн дугаар, байршил гэрээ, гэрчилгээний дугаар
	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр	Регистрийн дугаар	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр	Регистрийн дугаар									
1	Хамар Дагдандог Оюучимэг	MP76033006	Дуулиар Ганбаатар Энхриймаа	МЮ97070706	656	4308011330	Сүхбаатар сум 4-р баг Шүдэнзний 1-р гудамжны 147 тоот	656	656	Гэр бүлийн хамтын хэрэгцээний	2016 оноос 15 жил	2008 оноос 15 жил	Аймгийн Засаг даргын 2018-06-21-ны өдрийн А/248 тоот захирамжийн 1-р хавсралтын 2-д заасан Г. Энхриймаа /МЮ97070706/-д холбогдох хэсэг, 000738516 дугаартай гэрчилгээ, 2013.000240 дугаартай гэрээ
2	Боржигон Пунцагжунай Алтанхундага	МЮ84112272	Даяндээрхи Мянгар Ширмэнхүү	МЭ79042417	408	4308004508	Сүхбаатар сум 6-р баг Хайрхан 7-р гудамжны 716 тоот	408	408	Гэр бүлийн хамтын хэрэгцээний	2008 оноос 15 жил	2012/00442 дугаартай гэрээ	Аймгийн Засаг даргын 2012-10-04-ны өдрийн А/344 тоот захирамжийн 1-р хавсралтын 5-д заасан М.Ширмэнхүү /МЭ79042417/-д холбогдох хэсэг, 0399960 дугаартай гэрчилгээ, 2012/00442 дугаартай гэрээ
<b>НИЙТ</b>													